

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-9
1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асууда	4-6
1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	7-9

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 16-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Б.Баярбаатар, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд ирүүлснийг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Чөлөөлөх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбаямба, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 11 цаг 05 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Ирц бүрдсэн 53.1 хувьтай болсон байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн чуулганы хуралдаанд Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн, Жудгийн Баярмаа гишүүн ирсэн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн, Чинбатын Номин гишүүн ирсэн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирээд байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал хэлэлцэнэ.

1. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга гишүүнээс чөлөөлөх тухай асуудал,

2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

1. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал танаа 2025 оны 12 сарын 8-ны өдөр хүсэлт гаргах тухай

Миний бие Улсын Их Хурлын 2020 оны 26 дугаар тогтоолоор Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн даргаар томилогдсон. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт асны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргаж байгаа тул шийдвэрлэж өгнө үү.

Хүсэлт гаргасан Дэлгэрнаран гэсэн байна. П.Дэлгэрнаран.

Ингээд Дэлгэрнаран дарга Сонгуулийн ерөнхий хорооныхоо дарга гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байгааг Улсын Их Хуралд Улсын Их Хурлаас Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлээд, хуулиараа ажлын 3 хоногийн дараа хэлэлцэж чөлөөлнө гэсэн ийм Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1-д байгаа учраас энэ асуудлаар чөлөөлье өө.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя.

Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе ээ.

Мэдээж өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл санал гаргаж байгааг хүндэтгэж байна. Тэгээд үүнийг шийдвэрлэх нь зүйтэй. Гагцхүү ийм чухал байгууллагыг удирдлагагүй орхиж байгаа юм шиг ийм л шийдвэр болчих гээд байна. Тэгэхээр үүрэг гүйцэтгэгчээр хэнийг томилох вэ? Оронд нь хэн байх вэ? Ийм чухал Улсын Их Хурлын харьяа байгууллагыг түр үүргийг нь хэн гүйцэтгэх вэ гэдэг ийм асуулт байна.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн ерөнхий хороо 9 гишүүнтэй. Хуулиараа Төрийн байгуулалтын байнгын хорооноос 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс 2, Улсын дээд шүүхээс 2 гээд ингээд 9 гишүүнтэй ажилладаг. Дарга нарийн бичиг нь орон тооны. Бусад 7 гишүүд нь орон тооны бус гишүүн гэж ингэж явдаг юм байна аа.

Дэлгэрнаран дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран дарга өргөдлөө өгсөнтэй холбогдуулж, хуулийн хүрээнд томилгооны сонсгол явуулах ёстой. Томилгооны сонсгол хийх дараагийн хүн нь яг одоогоор тодорхой болоогүй учраас бид нар өнөөдөр Байнгын хорооноос тогтоол гаргана.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөөд тэгээд Сонгуулийн ерөнхий хорооны даргыг шинээр томилох хүртэл хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэхийг Нарийн бичгийн даргад нь орон тооных нь Нарийн бичгийн даргад дараагийн шинэ даргад томилогдох хүртэл хугацаанд Сонгуулийн ерөнхий хорооны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй аваад явах энэ чиглэлээр даалгасан ийм тогтоол гарч байгаа.

Тэгээд энэ хугацаанд Улсын Их Хурал намрын чуулгандаа багтах нь уу үгүй юу? Хугацаа нь томилгооны сонсгол чинь дор хаяж 14 хоногийн өмнө зарлан мэдээж нийтлэлд ингээд 14-өөс 30 хоногийн хугацаанд томилгооны сонсгол хийх, өнөөдөр

нөгөө Монголбанкны ерөнхийлөгч томилгооны сонсгол хийгдэж байгаа. Яг энэнтэй адилхан явагдах ёстой. Тийм учраас энэ процедур хуулийнхаа дагуу явагдана аа.

Тийм учраас өнөөдөртөө багтаагаад Дэлгэрнаран даргыг чөлөөлөөд, үүрэг гүйцэтгэгчээр Даваанямын Даваа-Очир Сонгуулийн ерөнхий хорооны одоогийн нарийн бичгийн даргад даалгасан ийм тогтоолыг танилцуулна аа.

Өөр асуулттай гишүүн байхгүй бол гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалтдаа бэлдье. Болсон уу?

Санал хураалт явууллаа.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя гишүүд ээ.

Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тогтоол Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг шинээр томилох хүртэл хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Нарийн бичгийн дарга Даваанямын Даваа-Очирт даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж. Асуулт байхгүй.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн унших вэ? Ариунзаяа гишүүн уншина аа.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

11.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж эхэлье ээ.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын зүгээс 2025 оны 6 сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулж байна.

Тус Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн агуулга рчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байна аа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны тан танилцуулга болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгөөрэй айн.

Зулпхар гишүүнээр тасаллаа.

Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Би ажлын хэсгээс нэг зүйл тодруулах гээд өнгөрсөн 7 хоногийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар орж ирж хэлэлцэж байхад Улсын Их Хурлын 2 гишүүн Номин гишүүн, Лодойсамбуу гишүүн энэ талаар тодорхой байр суурь

илэрхийлсэн. Тэр илэрхийлсэн байр суурь нь аль алиных нь тодорхой түвшинд үндэслэлтэй ийм байр суурь байсан юм байгаа юм.

Тэгэхээр энийг ер нь хууль санаачлагч нар яаж энд ахиж зохицуулж орж ирсэн бэ гэсэн ийм товчхон асуулт байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагч ажлын хэсгийн 5 номерын микрофон Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. 3 номерын микрофон юм байна шүү.

Б.Уянга: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Өнгөрсөн 7 хоногийн чуулганы санал хураалтаар одоо ер нь ямар зохицуулалт нь дэмжигдээд явж байгаа вэ гэхээр Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын ойн баяр, цагаан сар тухайн 7 хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн 7 хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна гэсэн зохицуулалтаар энэ хууль маань өөрчлөгдөх нь.

Анхны Батнайрамдал гишүүн бид 2-ын өргөн барьсан төсөл нь болохоор 2022 оноос хойш яг энэ Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд байж байгаад байхгүй болсон заалтыг буцаагаад оруулж ирсэн байсан юм. Тэгээд энэ маань хэлэлцэгдэж явж байгаад Засгийн газраас саналыг авахад зөвхөн Үндэсний их баяр наадам болон цагаан сар, наадмыгаа л ер нь авч үзье ээ гэсэн саналаар зарчмын зөрүүтэй санал гаргаад одоо ингээд дэмжигдээд явж байна.

Тэгэхээрээ энэ байдлаараа өөрчлөлт орсон гэсэн үг. Зулпхар гишүүний асуултад хариулахад.

Хоёрдугаарх нэг зүйл нь болохоороо түрүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх бас заавал бид нарт протоколд үлдээх ёстой нэг зүйлийг анхааруулсан. Тэр нь болохоороо төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн ийм хэзээ хэрэгжиж эхлэх вэ гэсэн огноог аж өгсөн алтыг хасах тухай байгаа. Тэгэхдээ энэ маань чуулган дээр дэмжигдээгүй учраас өнөөдөр төрийн байгуулалтаар хэлэлцэхгүй юм байна. Тэгэхдээ редакцын засвар юм уу ороод Цэцийн дүгнэлттэй учраас энэ холбогдох өөрчлөлтүүд нь хийгдээд явах байх гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Болсон уу? Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Би товчхон үг хэлчихье. Хууль их зөв болж орж ирж байна гэж байгаа юм. Нэг талаар бол Хөдөлмөрийн тухай хуулиар олгосон нийтээр тэмдэглэх баярын өдрийг бол амралтын өдөртэй давхцах юм бол ажлын өдөр рүү шилжүүлэх энэ зохицуулалт нь өөрөө орж ирж байна. Энэ бол сайн. Нийгмийн хөгжил талаасаа хүн амынхаа нийгмийнхээ жишээ нь гишүүдийн амралт ажлыг зөв зохицуулах талаасаа зөв. Нөгөө талдаа бас бүх өдрүүдийг ийм болгочих юм бол ажил олгогч талдаа их тийм хүндрэлтэй байдал үүсэх гээд байсан. Энэ хүндрэлтэй байдал мэдээж хэрэг ялангуяа жижиг болон дунд бизнес эрхлэгч нарт их хүнд тусахаар байсан. Энийг зохицуулсан ийм хэлбэр оруулж байгаа нь зөв болжээ гэсэн саналтай байна. Тэгээд энийг дэмжиж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ер нь ердийн горимоор хэрэг мөрдөгдөж эхэлнэ тийм ээ.

Та бүхэн оруулж ирэхдээ нөгөө шууд батлагдсан өдрөөс гэхихсэн байсан. Энэ нь өөрөө нөгөө Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг бүрэн эрхэд халдсан байна гэдэг асуудал Цэц яриад байгаа шүү дээ. Тийм учраас батлагдсан өдрөөсөө биш ердийн горимоор хэрэгжиж эхэлнэ шүү гэдгийг протоколд тэмдэглүүлээд үүнийгээ засаж яагаарай гэдгийг хэлсэн.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Яах вэ ер нь бол энэ хуулийг Улсын Их Хурал намрын чуулганаар хэлэлцээд баталчих нь зүйтэй. Хувийн хэвшлийнхэнд бас манай Номин гишүүнээр хэлэлцүүлгийн шатанд олон зүйлүүдийг ярьсан. Энэ ажил амралтаа зохицуулах асуудлууд, цаг хугацаа өгөх эртхэн шийдчихгүй бол ингээд Засгийн газар ер нь өмнөх жишгүүдийг харж байхад баяр наадмаар, цагаан сараар яах гэж байгаа нь мэдэгдэхгүй тулгаад тэгээд олон хүмүүс хувийн хэвшлийнхэн ажил төрлөө зохицуулах ажилтнуудынхаа амралт юмыг зохицуулах гээд ингээд тодорхойгүй байдаг учраас энэ жил эндээс сургамж аваад эртхэн хуулиа баталчихвал хувийн хэвшлийнхэн, төрийн байгууллагууд, ард иргэдэд ойлгомжтой болоод ажил төрлөө эртхэн зохицуулах бололцоо боломжийг нь олгож байгаа шүү гэдэг үүднээс бол хууль санаачлагч нар ингэсэн байгаа гэдгийг бас хэлье.

Танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Зулпхар гишүүн нэгмөсөн дуусгачих уу? Зулпхар гишүүн танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ.

Чуулгандаа идэвхтэй оролцсон Баярмаа гишүүн, Зулпхар гишүүн, Уянгахишиг гишүүн, Лодойсамбуу гишүүн, Одбаяр гишүүн, Шижир гишүүн, Пүрэвдорж гишүүн, Идэрбат гишүүн, Батжаргал гишүүн, Ариунзаяа гишүүн, Номин гишүүн, Хэрлэн гишүүн. Хүний нэр орхичхоогүй байгаа. Туваан гишүүн, Бат-Эрдэнэ гишүүнийг хэлсэн. Даваасүрэн гишүүн, Учрал дарга, гишүүдэд бас талархсанаа илэрхийлье ээ. Байнгын хороо хаасныг мэдэгдье.

11.25 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА